

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

\2016.09.25-2016.10.25\

НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Сумын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу сумаас алслагдсан өрхүүдтэй уулзалт хийх зорилгоор “Иргэдээ сонсьё” аяныг Зүүн болон баруун хэсгийн нутгийн иргэдтэй уулзлаа.

Тус аянд Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд эрхэлсэн ажлын чиглэлийн дагуу мэдээ тайлан бэлтгэж танилцуулан, гарын авлага, тараах материал тараан иргэдийн асуусан асуултанд хариулт өгч, санал шүүмжлэлийг хүлээн авч нийт 60 гаруй иргэд оролцсон ба аяны үеэр сумын Соёлын төвийн явуулын соёлын үйлчилгээ, явуулын номын сан ажиллуулан иргэдэд үйлчлэн, хүрэлцэн ирсэн иргэдийн дунд АХА тэмцээнийг зохион байгууллаа.



- “Нээлттэй-хаалга”-ны өдөрлөгийг төр, засгийн бодлого, шийдвэр, төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэх, иргэдийн санаа бодлыг сонсож үйл ажиллагаандаа тусгах үүднээс сумын албан байгууллагууд болон Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран 2016 оны 09-р сарын 28-ны өдрийн 10.00-17.00 цагт сумын төв талбайд зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр 4 байгууллагын 10 мэргэжилтэн ажил үүргийн дагуу холбогдох төрийн үйлчилгээг үзүүлж, мэдээ мэдээлэл хийв. Тус өдөрлөгт давхардсан тоогоор 262 иргэн үйлчлүүлснээс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын асуудлаар 52 иргэн, Оюуны өмч, улсын бүртгэлийн асуудлаар 28 иргэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудлаар 25 иргэн, “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-ын асуудлаар 54 иргэн үйлчлүүлж, 24 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, 158 ширхэг гарын авлага, тараах материал өгч, 103 иргэнийг зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллалаа.



- 2016 оны 2-р ээлжийн хугацаат цэрэг татлагын шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг Аймгийн цэрэг татлагын комисстой хамтран 2016.10.20-ны өдөр ЗДТГ-ын байранд зохион байгууллаа. Бүртгэлээр 21 иргэн буюу 33,3 хувьтай хамрагдсан бөгөөд 3-н иргэн тэнцэж, 18 иргэн эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй үзүүлэлттэй байна.




- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн хороонд 7 төрийн албан хаагч, 1-р тойргийн 471-р хэсгийн санал авах байранд 7 төрийн албан хаагч, 2-р тойргийн 472-р хэсгийн санал авах байранд 7 төрийн албан хаагч, нийт 21 төрийн албан хаагч ажиллалаа.



Сонгуулийн хорооны даргын 2016.10.17-ны өдрийн №10 тоот “Төлөвлөгөө батлах тухай” захирамжаар 1-р тойргийн 471-р хэсгийн санал авах байр, 2-р тойргийн 472-р хэсгийн санал авах байрны санал авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулж, санал авах үйл ажиллагаа өглөөний 07:00 цагт эхэлж, ирцийн мэдээг цаг тухай бүрт нь аймгийн сонгуулийн хороонд хүргүүлж оройн 22:00 цагийн хооронд сумын хэмжээнд 1998 сонгогчийн 1326 сонгогч буюу 66.3 хувь санал авах үйл ажиллагаанд оролцсон байна.

ХОЁР: ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

- 2016 оны 10-р сарын 05-ны өдөр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 2016 оны төсвийн тодотголийг хэлэлцүүлэн батлууллаа.
- Аймгийн орон нутгийн байгууллагын эд хариуцагч няравуудын үзүүлэх сургалтыг Шивээговь суманд 10-р сарын 21-ны өдөр зохион байгуулж санхүүгийн 45 ажилтан оролцсоноос сумын байгууллагуудын 6 нярав, 7 санхүүгийн ажилтан оролцлоо. Уг арга хэмжээний үер дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.
 - Аймгийн ерөнхий санхүүч Б. Соёлмаа Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагаа сэдэвт сургалт
 - Эрүүл мэндийн төв, 3-р цэцэрлэгээр орж няравууд туршлага солилцсон
 - Багуудын дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан.



ГУРАВ: НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

- Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд 2-16 насны хүүхдийн “Амны хөндийн үзлэг хийж, амны хөндийг эрүүлжүүлэх” арга хэмжээг 499,600 төгрөгийн төсөвтэйгээр сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран 2016 оны 09 сарын 26-наас 10 сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулж, сумын нийт 960 хүүхдэд амны хөндийн үзлэг хийж, улмаар хүнд



нөхцөлд амьдарч байгаа /хагас, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу өрхөд амьдардаг гэх мэт/нийт 71 хүүхдийн 300 шүдэнд эмчилгээ хийж, амны хөндийг эрүүлжүүлж ажилласан.

- Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд:

1. Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2016 оны 09 сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Арга хэмжээний үеэр сумын ахмадын хорооны дарга О.Төмөрчулуун сонгуульт хугацаандаа хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, хорооны шинэ даргаар ил санал



хураалт явуулан сумын ахмад настан Б.Оюунбатыг сонгосон.

- Сумын “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаанаас Шилдэгээр шалгарсан 2 иргэнээр удирдуулан иргэдэд “Хүнсний ногоо тариалалт, хадгалалт”, “Гар урлал, чимэглэл”-ийн чиглэлээр 4 өдрийн сургалтыг 606,200 төгрөгийн төсөвтэйгээр зохион байгууллаа.

- Олон улсын багш нарын баярыг тохиолдуулан “Боловсролын Тэргүүний ажилтан” цол тэмдгээр-4, БСШУСЯ-ны “Жуух бичиг”-ээр-1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналаар-1, сумын Засаг даргын “Баярын бичиг”-



ээр-2 багш тус тус шагнагдсан.

ДӨРӨВ: БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Гуравдугаар сургууль:

- Монголын багш нарын баярыг угтаж “Ур чадвар-2016” уралдааныг 2016



оны 09 дүгээр сарын 26-30-ны хооронд амжилттай зохион байгууллаа.

- Сургуулийн “НОМ” хөтөлбөрийн багийн гишүүдтэй хамтран 2016 оны 10 сарын 10-нд II-V ангийн сурагчдын дунд уншсан номын агуулгаар АХА тэмцээн, багш ажилчдын дунд “Монголын нууц товчоо” номын агуулгаар “Алтан хонх” хөгжөөнт тэмцээнийг тус тус зохион байгуулж, тэргүүний хүмүүсээ шалгарууллаа.



- ЕБ-ын дунд сургуулийн багш, сурагчдын математикийн мэдлэгийг дээшлүүлэх, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, харилцан туршлага судлах зорилгоор “МОНГОЛ УЛСЫН МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫГ



ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО”-ноос зохион байгуулдаг А.Батмөнхийн нэрэмжит бүсийн олимпиадад 3-р сургуулийн баг амжилттай оролцож, 6^а ангийн сурагч Н.Гэрэлттунгалаг хүрэл медалийг хүртлээ.

- Аймгийн засаг даргын нэрэмжит багш нарын индексийн уралдаанд Л.Цолмон багштай 2^б ангийн хамт олон “ТЭРГҮҮНИЙ АНГИ ХАМТ ОЛОН”-оор шалгаран олон улсын хүүхдийн “НАЙРАМДАЛ” зусланд 3 хоног амрах эрхийн бичгээр шагнуулж 10 сарын 15-наас 10 сарын 18-ны



хооронд амраад ирлээ.

Гуравдугаар цэцэрлэг:

- “Шивээ-Овоо” ХК-ийн 25 жилийн ойн хүрээнд цэцэрлэгийн Бэлтгэл “Б” бүлгийн сургалтын орчинг 9 сая төгрөгийн санхүүжилтээр Үлгэр жишээ анги болгон тохижууллаа.



- Багш нарын баяр угтан хүүхдийн насны онцлогт тохирсон тестийг боловсруулж, ном болгон хэвлүүлэн багшийн бүтээлийн сан, тэргүүн туршлагаа түгээх зорилгоор “Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тест боловсруулах” уралдаан зарлаж дүнгээ гаргалаа.



Эрүүл мэндийн төв:

- Эрүүлмэндийнтөвийнүйлажиллагаахэвийнявагдажбайна.10сардэмнэлэгт хэвтсэн36,Амбулаторийнүзлэг405,Урьдчилансэргийлэх237,Дуудлага50
- Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газраас Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Хепатит В вирусын халдвараас сэргийлье” уриан дор 2016 оны 10 дугаар сарын 03-13-ны хооронд зохион байгуулж байгаатай холбогдуулан сумын 6 сараас 5 нас хүртэлх насны хүүхдэд А витамин уулгаж, Ерөнхий боловсролын 7, 15 насны хүүхдүүдэд Сахуу татрангийн



- дархлаажуулалтыг 122 хүүхдэд хийсэн.
- Томуу, томуу төст өвчлөлийн дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан сэрэмжлүүлэг зөвлөмжийг 3-р сургууль, 3-р цэцэрлэгийн эмч нарт хүргүүлэн зөвлөмжийн дагуу ажиллах зөвлөгөө өгсөн. Мөн Facebook хуудсаар Томуу, томуу төст өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудсыг байршуулан иргэдэд мэдээлэл өгч ажилласан.
 - Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх аяны хүрээнд “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-ын ажилтнуудад 10 сарын 21-ний өдөр “Эмийн зохистой хэрэглээ”, “Анхны тусламж” сургалтыг тус тус зохион байгуулсан.



ТАВ: УЛСЫН БҮРТГЭЛ

- Иргэний бүртгэлийн үйлчилгээг 70 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 17 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.
- Газраа анх удаа өмчилж авч байгаа 91 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2016 ОНЫ 10 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	77				85	43	42
Төрсөн эх	2	75				83		83
Бүртгүүлсэн гэр бүл	3	18				19	19	19
Нас баралт	4	18				20	8	12
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	77				77	40	37
Аймаг, нийслэлрүү шилжин явсан	8	70				70	36	34

СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэртөрөл	2016 оны 10-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Иргэний үнэмлэхний үнэ	15000	21	315000	3300	21	69300	
2	Эцэг тогтоолт	2500	6	15000				
3	Гэрлэлтийн гэрчилгээ	2500	1	2500				
4	Төрсний гэрчилгээ дахин авалт	5000	1	5000				
ДҮН		335000			69300			
НИЙТ ДҮН		404300						

ЗУРГАА: НИЙГМИЙН ДААТГАЛ

- Эрүүл мэндийн шимгэл сайн дураар төлдөг иргэд 3-р улирлын байдлаар 4,139,280 төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Сайн дурын даатгалд нийт 103 иргэн даатгуулсанаас:
 - Малчин иргэн- 59
 - Ажилгүй иргэн- 32
 - Хувиараа бизнес эрхлэгч-1
 - Оюутан- 11 тус тус шинээр даатгуулсан.

ДОЛОО: ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ

- Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2016 оны 10-р сарын 06, 15-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулан 14 иргэний өргөдөл ирснийг хэлэлцэн 100 хувь шийдвэрлэсэн. Үүнд: Н.Цагаан, Д.Ичинноров, З.Пүрэвтогтох, Ч.Одгэрэл, Ш.Батсайхан, нар - Эмнэлгийн хяналтанд байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан асарч байгаа иргэнд сар бүр олгодог асаргааны мөнгөн тэтгэмжийн сунгалт хийлгэсэн. Н.Оюунтунгалаг, Х.Дэчинсүрэн, Ё.Үүрийнцолмон, Г.Отгон, Ж.Долгор нар - Байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд улирал бүр олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалт хийлгэсэн.

- Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу бүрэн хараагүй, хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагтай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа тусламж олгох ажлын хүрээнд Шивээговь сумын хөгжлийн бэрхшээлтэй 22 иргэнд 3080000 төгрөгийг олгоод байна.
- “Тэгш дүүрэн хөтөлбөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд малжуулах зорилгоор олгодог ямааг 4 өрхөд хүлээлгэн өгч гэрээг байгуулаад байна.
- Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 8 өрхийн 8, 9-р сарын хүнсний талоныг хүлээлгэн өгч, гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан 910000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгоод байна.

НАЙМ: МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГ

- Сумын хэмжээнд “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 14 иргэн, 1 албан байгууллага 7 төрлийн /хүнсний ногоо, талх, нарийн боов, цагаан идээ, хоол үйлдвэрлэл, оёдол, гар урлал, номын худалдаа/ бараа, бүтээгдэхүүнээр амжилттай оролцож нийт 1,065,000 төгрөгийн борлуулалт хийлээ.



- Ургац хураалтын эцсийн мэдээгээр төмс-13,7 тн, хүнсний ногоо-72,5 тонныг хураан авсан.
- “Иргэдийг малжуулах журам”-ын дагуу 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр дараах иргэдэд 36 хонь, 16 ямааг хүлээлгэн өгсөн.

Д.Ганбаатар, С.Батцэцэг, М.Алтангэрэл, Б.Батбаатар



- “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх ажлын хэсэг” 10 дугаар сарын 21-ний өдрөөс вакцинжуулалтын ажил эхэлсэн ба одоогийн байдлаар 27 өрхийн 16,651 толгой мал хамрагдаад байна.
- “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсэг байгуулагдан сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж болон хөдөөгийн малчин өрхүүдийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2 удаа шалгаж заавар, зөвлөмжийг өгч ажиллаж байна. Сумын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 91%-тай байна.




- “Ургац-2016” уралдаанд 3-р цэцэрлэг, Т.Ганбаатар, “Худаг-2016” уралдаанд малчин Ж.Батсүх нарыг тус тус тодорхойлж холбогдох материалыг аймгийн ХХААГ-т хүргүүлсэн.

ЁС: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ

- “Өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх” ажлын хүрээнд Алтанбулаг Уул ХХК-тай 1074 боодол өвс худалдан авахаар гэрээ байгуулан өвсөө авч агуулахад нөөцлөөд байна.



- Соёлын төвийн сантехникийн засварын ажлыг иргэн Н. Чулуунтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн хүлээн авахад бэлэн болоод байна.



Мэдээ боловсруулсан: НЗЭЗАХМэргэжилтэн Б.Мөнхцэцэг